

2024.10.04

1. ТАНИЛЦУУЛГА

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Дархан-Уул аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар болон харьяа соёлын 7 байгууллагын шилэн данс цахим хуудасны “Төсөв, гүйцэтгэл”, “Хөрөнгө оруулалт, худалдан авалт”, “Бусад” гэсэн 3 цэсэд байршуулсан 22 нэр төрлийн 87 удаагийн мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлсэн эсэхэд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6 дахь заалт, 69 дүгээр зүйлийн 69.3 дахь хэсэг, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Соёлын сайдын 2021 оны А/43 дугаар тушаалаар баталсан “Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам”-ыг тус тус үндэслэн Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод хяналтыг хийж гүйцэтгэлээ.

Дотоод хяналтын ажлын тайланг Дархан-Уул аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар болон харьяа соёлын 7 байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтанд танилцуулж, илэрсэн алдаа дутагдлыг 14 хоногийн хугацаанд залруулах арга хэмжээг авч аймгийн хэмжээнд дүнг нэгтгэн дүгнэлээ.

2. ДОТООД ХЯНАЛТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА

2.1. Зорилго

Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, шилэн дансны цахим хуудасны 2024 оны эхний хагас жилийн хөтлөлт, мэдээлэл байршуулсан байдал, холбогдох баримт бичгийг бүрэн оруулсан байдалд хяналт тавьж, дүн шинжилгээ хийх, гаргасан алдаа, илэрсэн зөрчлийг арилгуулахад гол зорилго оршсон.

2.2. Хамрах хүрээ

Дотоод хяналтад аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар болон харьяа соёлын байгууллага болох Залуучууд театр, Музей, Төв номын сан, Хүүхдийн номын ордон болон Орхон, Хонгор, Шарын гол сумдын соёлын төвийн 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг дуусталх хугацааны шилэн дансны мэдээлэл байршуулалт болон хөтлөлтийн үнэн зөв, бодитой, иж бүрэн тайлагнасан байдалд нарийвчилсан хяналт тавьж ажиллалаа.

2.3. Дотоод хяналт гүйцэтгэсэн арга

Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны “Төсөв ба гүйцэтгэл”, “Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт”, “Бусад” гэсэн цэсэд оруулсан мэдээллийг хууль,

журам зааврын дагуу үнэн зөв, бодитой, иж бүрэн, хуулийн хугацаанд оруулсан эсэхэд үнэлгээ өгсөн болно.

Дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэхдээ төсөвт байгууллагуудын тайлант хугацаанд хамаарах шилэн дансанд байршуулсан мэдээллийг төрийн сангийн дансны хуулга, удирдлагын гаргасан хөрөнгө мөнгө зарцуулсан тушаал шийдвэртэй тулган шалгаж, нэмэлт тайлбар тодруулга мэдээллийг байгууллагын нягтлан бодогч болон бусад ажилтнаас авсан. Эдгээр дотоод хяналтыг хэрэгжүүлэхдээ дараах хууль, эрх зүйн баримтуудыг ашигласан. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”

3. ДОТООД ХЯНАЛТЫН ҮР ДҮН

3.1. Илэрсэн асуудал

Илэрсэн асуудал 3.1.1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тус аймгийн соёлын салбарын 8 төсөвт байгууллага 2024 оны эхний хагас жилийн дүнгээр 10 талбарт байршуулах мэдээллийг хугацаа хоцроосон, мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн байх шалгуурыг хангаагүй 27 алдаа, дутагдал илэрсэн. Шилэн дансны хуулийн хэрэгжилт дунджаар 96.1 хувьтай байна.

Хүснэгт №1

№	Үзүүлэлт	Мэдээлэл оруулсан давтамжийн тоо	Үүнд:		Шилэн дансны хөтлөлт -ийн хувь	Үнэн зөв, бодиттой, иж бүрэн байдлын үнэлгээ	
			Хугацаа -ндаа	Хугацаа хоцроосон		Илэрсэн алдаа зөрчлийн тоо	Хэрэгжилт ийн хувь
	Салбарын нэгдсэн дүн	696	690	6	99.1	27	96.1
1	СУАЖЗГ	87	84	3	96.6	2	97.7
2	Залуучууд театр	87	87	0	100	4	95.4
3	Төв номын сан	87	87	0	100	6	95.4

4	Музей	87	87	0	100	6	93.1
5	Хүүхдийн номын ордон	87	86	1	98.9	2	94.3
6	Орхон сумын Соёлын төв	87	87	0	100	1	96.6
7	Хонгор сумын Соёлын төв	87	87	0	100	3	95.4
8	Шарын гол сумын Соёлын төв	87	85	2	97.7	3	96.6

Илэрсэн асуудал 3.1.2. Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдлыг шалгахад 33 удаагийн 371.0 сая төгрөгийн орлогын гүйлгээ, 3 удаагийн 15.3 сая төгрөгийн зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь мэдээлэх ёстой орлогын гүйлгээний 34.4 хувийг, зарлагын гүйлгээний 8.8 хувийг эзэлж байна.

Хүснэгт №2

№	Байгууллагын нэр	5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий гүйлгээ	Мэдээлвэл зохих гүйлгээ		Мэдээлсэн гүйлгээний		Мэдээлээгүй гүйлгээний	
			Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/
1	СУАЖЗГ	орлого	10	244.3	8	207.9	2	36.4
		зарлага	3	39.0	3	39.1	0	-
2	Залуучууд театр	орлого	23	1,993.7	22	1,930.8	1	62.9
		зарлага	14	127.0	14	127.0	0	-
3	Төв номын сан	орлого	7	309.7	5	237.0	2	72.7
		зарлага	2	47.2	2	47.2	0	-
4	Музей	орлого	6	121.7	4	119.1	2	2.6
		зарлага	0	-	0	-	0	-
5	Хүүхдийн номын ордон	орлого	7	211.1	7	211.1	0	-
		зарлага	0	-	0	-	0	-
6	Орхон сум Соёлын төв	орлого	11	93.3	11	93.3	0	-
		зарлага	5	77.9	5	77.9	0	-
7	Хонгор сум Соёлын төв	орлого	13	100.8	4	43.3	9	57.5
		зарлага	4	20.8	2	10.4	2	10.4
8	Шарын гол сум Соёлын төв	орлого	19	192.5	2	53.6	17	138.9
		зарлага	6	37.6	5	32.7	1	4.9
Нийт дүн		Орлого	96	3,267.1	63	2,896.1	33	371.0
		Зарлага	34	349.5	31	334.2	3	15.3

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын 36 удаагийн 386.3 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй зөрчлийн 35.1% үр дүнд суурилсан санхүүжилтийн орлого, 60.9% нь санхүүжилтийн орлого, 4% нь бусад орлого болон зарлагын гүйлгээг мэдээлээгүйгээс шалтгаалжээ.

Илэрсэн асуудал 3.1.3. Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 16 удаагийн 371.4 сая төгрөгийн гүйлгээ

гарснаас 2 удаагийн 16.1 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь мэдээлвэл зохих гүйлгээний 12.5 хувийг эзэлж байна.

Хүснэгт №3

№	Байгууллагын нэр	5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт					
		Мэдээлвэл зохих гүйлгээний		Мэдээлсэн гүйлгээний		Мэдээлээгүй гүйлгээний	
		Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/
1	СУАЖЗГ	2	30.3	2	30.3	0	-
2	Залуучууд театр	1	7.1	0	-	1	7.1
3	Төв номын сан	1	9.0	0	-	1	9.0
4	Музей	0	-	0	-	0	-
5	Хүүхдийн номын ордон	0	-	0	-	0	-
6	Орхон сумын Соёлын төв	4	175.6	4	175.6	0	-
7	Хонгор сумын Соёлын төв	0	-	0	-	0	-
8	Шарын гол сумын Соёлын төв	8	149.4	8	149.4	0	-
Нийт дүн		16	371.4	14	355.3	2	16.1

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтыг мэдээлэхдээ таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээнд мэдээлсэн боловч худалдан авалт дээр мэдээлээгүй 2 алдаа гарсан байна. Уг худалдан авалтын мөнгөн дүн нь нийт алдааны 100 хувийг эзэлж байна.

Илэрсэн асуудал 3.1.4 Хөрөнгө, мөнгө захиран зарцуулах тухай 15.7 сая төгрөгийн 11 тушаал шийдвэрийг шилэн дансанд мэдээлээгүй байна.

Дархан-Уул аймгийн соёлын салбарын 8 төсвийн шууд захирагчид өөрийн эрх хэмжээний хүрээнд хөрөнгө, мөнгө захиран зарцуулах тухай 157.1 сая төгрөгийн 72 тушаал шийдвэрийг гаргаж, үүнээс шилэн дансны цахим хуудсанд 141.4 сая төгрөгийн 61 тушаал шийдвэрийг мэдээлж, мэдээллийн ил тод байдлыг 84.7 хувиар хангаж ажилласан байна.

Хүснэгт №4

№	Байгууллагын нэр	Хөрөнгө мөнгө зарцуулсан гэрээ, тушаал					
		Мэдээлвэл зохих шийдвэрийн		Мэдээлсэн шийдвэрийн		Мэдээлээгүй шийдвэрийн	
		Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/
1	СУАЖЗГ	16	89.6	16	89.6	0	-
2	Залуучууд театр	24	34.0	24	34.0	0	-
3	Төв номын сан	7	4.6	0	-	7	4.6
4	Музей	13	15.9	9	4.8	4	11.1
5	Хүүхдийн номын ордон	0	-	0	-	0	-
6	Орхон сумын Соёлын төв	5	5.4	5	5.4	0	-
7	Хонгор сумын Соёлын төв	6	1.4	6	1.4	0	-
8	Шарын гол сумын Соёлын төв	1	6.2	1	6.2	0	-
Нийт дүн		72	157.1	61	141.4	11	15.7

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулах үүрэгтэй албан хаагч болон нягтлан бодогчид хууль, тогтоомжийн хугацаа баримтлаагүйгээс хөрөнгө, мөнгө

захиран зарцуулсан тушаал, шийдвэрийг шилэн дансанд мэдээлээгүй алдаа дутагдал гаргасан байна. Мөн хөрөнгө мөнгө зарцуулах тушаал гаргах болон гэрээ байгуулахдаа “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг гаргаагүй, эсхүл гаргасан хэдий ч цахимд байршуулаагүй зэрэг зөрчил гаргасан байна.

3.2. Зөвлөмж

Тайлант онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээг сар бүр мэдээлээгүй буюу санхүүжилтийн орлогыг өссөн дүнгээр оруулсан алдаа, зөрчил дийлэнх хувийг эзэлж байна. Энэ нь мэдээллийн үнэн зөв, бодиттой, иж бүрэн байх зарчмыг хангах хуулийн заалтыг зөрчиж буй хэрэг юм. Мөн дотоод хяналтын дүнгээр нэр бүхий 8 байгууллагад илэрсэн алдааг арилгах зорилгоор мэргэжил арга зүйн зөвлөгөөг тус байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч /ахлах/ нарт өгсөн.

Зөвлөгөө-1: Дээрх алдаа, зөрчил гаргасан байгууллагууд сар бүрийн санхүүжилтийн орлогыг тухай бүр болон гүйлгээ хийгдснээс 7 хоног дотор тодорхой дүнгээр оруулж байх;

Зөвлөгөө -2: Дотоод хяналтад хамрагдсан байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилтийн бодит байдал, илэрсэн алдаа, цаашид анхаарах асуудлыг тусгасан товч тайлан, зөвлөмжийг байгууллага тус бүрт хүргүүлсэн тул биелэлтийг хангаж хэрэгжилтийн тайланг 2024 оны 10 дугаар сарын 18-ны дотор тус газарт ирүүлэх;

Зөвлөгөө -3: Тайлант хугацаанд байгууллагын дарга нар иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ, хөрөнгө мөнгө зарцуулсан тушаал шийдвэртэй холбоотой “Ашиг сонирхлын мэдэгдэл” гаргаагүй, гаргаснаа мэдээлээгүй алдаа, зөрчил их байгаа тул уг мэдэгдлийг тогтмол гаргаж мэдээлж хэвших;

Зөвлөгөө -4: Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ болон худалдан авалтын талаар мэдээлэхдээ мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангаж байх буюу харилцагч байгууллагын хаягийн мэдээллийг иж бүрэн мэдээлж байх;

Үүнд: Дотоод хяналтаар алдаа гаргасан байгууллагуудын мэдээлэл:

№	Байгууллагын нэр	5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мэдээлээгүй гүйлгээний		5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлээгүй гүйлгээний		Хөрөнгө мөнгө захиран зарцуулсан тушаал шийдвэрийн мэдээлээгүй гүйлгээний	
		Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/

1	СУАЖЗГ	орлого	2	36.4	0	-	0	-
		зарлага	0	-				
2	Залуучууд театр	орлого	1	62.9	1	7.1	0	-
		зарлага	0	-				
3	Төв номын сан	орлого	2	72.7	1	9.0	7	4.6
		зарлага	0	-				
4	Музей	орлого	2	2.6	0	-	4	11.1
		зарлага	0	-				
5	Хүүхдийн номын ордон	орлого	0	-	0	-	0	-
		зарлага	0	-				
6	Орхон сум Соёлын төв	орлого	0	-	0	-	0	-
		зарлага	0	-				
7	Хонгор сум Соёлын төв	орлого	9	57.5	4	20.8	0	-
		зарлага	2	10.4				
8	Шарын гол сум Соёлын төв	орлого	17	138.9	0	-	0	-
		зарлага	1	4.9				
Нийт дүн		Орлого	33	371.0	2	16.1	11	15.7
		Зарлага	3	15.3				

4. ДҮГНЭЛТ

Дархан-Уул аймгийн хэмжээнд соёлын байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт дунджаар 96.1%-тай байна.

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын 130 удаагийн нийт 3,616.6 сая төгрөгийн гүйлгээ мэдээлэгдэхээс 94 удаагийн 3,230.3 сая төгрөгийн гүйлгээ шилэн дансны цахим системд мэдээлсэн байна. Энэ нь нийт мэдээлвэл зохих мэдээллийн 72.4%-ийг эзэлж байна.

Мөн 157.1 сая төгрөгийн нийт 72 тушаал, шийдвэрийг шилэн дансны цахим системд мэдээлэхээс 141.4 сая төгрөгийн 61 тушаал, шийдвэрийг мэдээлсэн нь удирдлагын түвшинд гаргасан санхүүгийн шийдвэр, захиран зарцуулах үйл ажиллагааны мэдээллийг бүрэн, ил тод байлгах шаардлагын хэрэгжилтийг дунджаар 84.7%-иар хангасан үзүүлэлттэй байна.

Дотоод хяналтаар илэрсэн алдаа, дутагдлууд нь санхүүгийн үйл ажиллагааны үндсэн зарчимд нөлөөлөхүйц бус хэдий ч мэдээлэх ёстой зарим гүйлгээг мэдээлээгүй, тодорхой бус мэдээллүүд байршуулсан нь нийт алдааны дийлэнх хувийг эзэлж байна.

Цаашид авах арга хэмжээний санал:

➤ Санхүүгийн үйл ажиллагааны мэдээллийн үнэн зөв, ил тод байдлыг хангаж, санхүүгийн бүх төрлийн гүйлгээ болон тушаал, шийдвэрүүдийг хуулийн хугацаанд шилэн дансны системд байршуулах тал дээр удирдлагын түвшинд ач холбогдол өгч, хариуцлагатай хандах;

- Дотоод хяналтыг тогтмол хийж, илэрсэн алдаа, дутагдлыг цаг тухайд нь залруулах арга хэмжээг авч, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахад анхаарч ажиллах;
- Илэрсэн алдаа, дутагдлуудыг давтан гаргахгүй байх;

ТАНИЛЦСАН:
ГАЗРЫН ДАРГА



Х.СОЁЛ-ЭРДЭНЭ

2024 оны 10 дугаар сарын 04 ны өдөр

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

С.ТУЯА

2024 оны 10 дугаар сарын 04 ны өдөр

ТАЙЛАН БИЧСЭН:
ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АСУУДАЛ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН:

П.ЦОГЦЭЦЭГ

2024 оны 10 дугаар сарын 04 ны өдөр

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛЫН САЛБАРЫН ШИЛЭН ДАНСНЫ 2024 ОНЫ ЭХНИЙ
ХАГАС ЖИЛИЙН ДОТООД ХЯНАЛТЫН ХАВСРАЛТ СУДАЛГАА**

Маягт №1

№	Байгууллагын төрөл	Байгууллагын тоо	Хуулийн үйлчлэл
1	Төсвийн байгууллага	8	Шилэн дансны тухай хуулийн 3.1.1
2	ТӨХК, ОНӨХК, ТӨҮГ, УТҮГ, ОНӨҮГ		
3	Төсөл, Хөтөлбөр		
4	Засгийн газрын тусгай сангууд болон бусад сан		
5	ТББ, Нөхөрлөл хоршоо, Аж ахуйн нэгж		
	Нийт	8	

Маягт №2

№	Мэдээллийн төрөл	Нийт мэдээлэх	Мэдээлсэн	Үүнд:		Хэрэг-жилтийн хувь
				Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа хоцорсон	
1	Бүтэн жилээр оруулах мэдээлэл	5	5	2	3	40
2	Хагас жилээр оруулах мэдээлэл	4	4	3	1	75
3	Улирал бүрийн мэдээлэл					
4	Сар бүрийн мэдээлэл	24	24	22	2	91.6
5	Тухай бүрийн мэдээлэл	54	54	50	4	92.5
	Нийт	87	87	77	10	74.7

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН
ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН МЭДЭЭ**

Маягт №03

№	Байгууллагын нэр	Мэдээлэл оруулах давтамжийн тоо	Мэдээлэл оруулсан давтамжийн тоо	Үүнд:		Хөтлөлт -ийн хувь	Үнэн зөв, бодиттой, иж бүрэн байдлын үнэлгээ	
				Хугацаа -ндаа	Хугацаа хоцроосон		Илэрсэн алдаа зөрчлийн тоо	Хэрэг-жилтийн хувь
1	СУАЖЗГ	87	87	84	3	96.6	2	97.7
2	Залуучууд театр	87	87	87	0	100.0	4	95.4
3	Төв номын сан	87	87	87	0	100.0	6	93.1
4	Музей	87	87	87	0	100.0	6	93.1
5	Хүүхдийн номын ордон	87	87	86	1	98.9	2	97.7
6	Орхон сумын Соёлын төв	87	87	87	0	100.0	1	98.9
7	Хонгор сумын Соёлын төв	87	87	87	0	100.0	3	96.6
8	Шарын гол сумын Соёлын төв	87	87	85	2	97.7	3	96.6
Нийт		696	696	690	6	99.1	27	96.1

**Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш дүн бүхий
орлого, зарлагын гүйлгээний дүн мэдээ**

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээ						Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ					
		Мэдээлэл зохих гүйлгээний		Мэдээлсэн гүйлгээний		Мэдээлээгүй гүйлгээний		Мэдээлэл зохих гүйлгээний		Мэдээлсэн гүйлгээний		Мэдээлээгүй гүйлгээний	
		Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/
1	СУАЖЗГ	10	244.3	8	207.9	2.0	36.4	3	39.0	3	39.0	-	-
2	Залуучууд театр	23	1,993.7	22	1,930.8	1.0	62.9	14	127.0	14	127.0	-	-
3	Төв номын сан	7	309.7	5	237.0	2.0	72.7	2	47.2	2	47.2	-	-
4	Музей	6	121.7	4	119.1	2	2.6	0	-	-	-	-	-
5	Хүүхдийн номын ордон	7	211.1	7	211.1	-	-	0	-	-	-	-	-
6	Орхон сумын Соёлын төв	11	93.3	11	93.3	-	-	5	77.9	5	77.9	-	-
7	Хонгор сумын Соёлын төв	13	100.8	4	43.3	9	57.5	4	20.8	2	10.4	2	10.4
8	Шарын гол сумын Соёлын төв	19	192.5	2	53.6	17	138.9	6	37.6	5	32.7	1	4.9
Нийт		96	3,267.1	63	2,896.1	33	371.0	34	349.5	31	334.2	3	15.3

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ГАЗАР

**Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан
бараа, ажил үйлчилгээний зардлын гүйлгээний дүн, мэдээ**

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Таван сая төгрөгөөс дээш худалдан авалтын					
		Мэдээлвэл зохих гүйлгээний		Мэдээлсэн гүйлгээний		Мэдээлээгүй гүйлгээний	
		Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/
1	СУАЖЗГ	2	30.3	2	30.3	-	-
2	Залуучууд театр	1	7.1			1.0	7.1
3	Төв номын сан	1	9.0	-	-	1.0	9.0
4	Музей					-	-
5	Хүүхдийн номын ордон					-	-
6	Орхон сумын Соёлын төв	4	175.6	4	175.6	-	-
7	Хонгор сумын Соёлын төв	0	-	-		-	-
8	Шарын гол сумын Соёлын төв	8	149.4	8	149.4	-	-
Нийт		16	371.4	14	355.3	2	16.1

**Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн аливаа
тушаал, шийдвэрийн дүн, мэдээ**

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Хөрөнгө мөнгө зарцуулсан гэрээ, тушаал					
		Мэдээлвэл зохих шийдвэрийн		Мэдээлсэн шийдвэрийн		Мэдээлээгүй шийдвэрийн	
		Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/
1	СУАЖЗГ	16	89.6	16	89.6	-	-
2	Залуучууд театр	24	34.0	24	34.0	-	-
3	Төв номын сан	7	4.6			7.0	4.6
4	Музей	13	15.9	9	4.8	4	11.1
5	Хүүхдийн номын ордон					-	-
6	Орхон сумын Соёлын төв	5	5.4	5	5.4	-	-
7	Хонгор сумын Соёлын төв	6	1.4	6	1.4		-
8	Шарын гол сумын Соёлын төв	1	6.2	1	6.2	-	-
Нийт		72	157.1	61	141.4	11	15.7

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ГАЗАР

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХҮРЭЭНД МЭДЭЭЛЭХ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТИЙН СУДАЛГАА

№	Байгууллагын нэр	Мэдээлэл оруулах давтамжийн тоо	Мэдээлэл оруулсан давтамжийн тоо	Үүнд:		Хөтлөлт - ийн хувь	Үнэн зөв, бодиттой, иж бүрэн байдлын үнэлгээ		Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээ					
				Хугацаа - ндаа	Хугацаа хоцроосон		Илэрсэн алдаа зөрчлийн тоо	Хэрэгжилтийн хувь	Мэдээлэл зохих гүйлгээний		Мэдээлсэн гүйлгээний		Мэдээлээгүй гүйлгээний	
									Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/
1	СУАЖЗГ	87	87	84	3	96.6	2	97.7	10	244.3	8	207.9	2.0	36.4
2	Залуучууд театр	87	87	87	0	100.0	4	95.4	23	1,993.7	22	1,930.8	1.0	62.9
3	Төв номын сан	87	87	87	0	100.0	6	93.1	7	309.7	5	237.0	2.0	72.7
4	Музей	87	87	87	0	100.0	6	93.1	6	121.7	4	119.1	2	2.6
5	Хүүхдийн номын ордон	87	87	86	1	98.9	2	97.7	7	211.1	7	211.1	-	-
6	Орхон сумын Соёлын төв	87	87	87	0	100.0	1	98.9	11	93.3	11	93.3	-	-
7	Хонгор сумын Соёлын төв	87	87	87	0	100.0	3	96.6	13	100.8	4	43.3	9	57.5
8	Шарын гол сумын Соёлын төв	87	87	85	2	97.7	3	96.6	19	192.5	2	53.6	17	138.9
Нийт		696	696	690	6	99.1	27	96.1	96	3,267.1	63	2,896.1	33	371.0

ХЯНАСАН: ГАЗРЫН ДАРГА

Х СОЁЛ-ЭРДЭНЭ

ТАЙЛАГНАСАН: ТӨСВИЙН МЭРГЭЖИЛТЭН

П ЦОГЦЭЦЭГ



Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ						Таван сая төгрөгөөс дээш худалдан авалтын						Хөрөнгө мөнгө зарцуулсан гэрээ, тушаал					
Мэдээлвэл зохих гүйлгээний		Мэдээлсэн гүйлгээний		Мэдээлэгүй гүйлгээний		Мэдээлвэл зохих гүйлгээний		Мэдээлсэн гүйлгээний		Мэдээлэгүй гүйлгээний		Мэдээлвэл зохих гүйлгээний		Мэдээлсэн гүйлгээний		Мэдээлэгүй гүйлгээний	
Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/	Тоо	Төгрөг /сая/
3	39.0	3	39.0	-	-	2	30.3	2	30.3	-	-	16	89.6	16	89.6	-	-
14	127.0	14	127.0	-	-	1	7.1	-	-	1.0	7.1	24	34.0	24	34.0	-	-
2	47.2	2	47.2	-	-	1	9.0	-	-	1.0	9.0	7	4.6	-	-	7.0	4.6
0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	13	15.9	9	4.8	4	11.1
0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	77.9	5	77.9	-	-	4	175.6	4	175.6	-	-	5	5.4	5	5.4	-	-
4	20.8	2	10.4	2	10.4	0	-	-	-	-	-	6	1.4	6	1.4	-	-
6	37.6	5	32.7	1	4.9	8	149.4	8	149.4	-	-	1	6.2	1	6.2	-	-
34	349.5	31	334.2	3	15.3	16	371.4	14	355.3	2	16.1	72	157.1	61	141.4	11	15.7

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ГАЗРЫН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ДОТООД ХЯНАЛТЫН ТАЙЛАН**

2024.09.26

Д/д	Мэдээллийн нэр төрөл	Талбар -ын тоо	Бодит байдал, илэрсэн зөрчил, анхаарах асуудал
Төсөв ба гүйцэтгэл		35	
1	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-эдийн засгийн ангилал	6	2024 оны 01-05 дугаар сарын төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн талаарх мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн. 2024 оны 06 дугаар сард хугацаа хоцроосон.
2	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – хөтөлбөр, зориулалт	6	2024 оны 01-05 дугаар сарын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хөтөлбөр, зориулалтын талаарх мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн. 2024 оны 06 дугаар сард хугацаа хоцроосон.
3	Санхүүгийн тайлан	1	2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн.
4	Хандив, тусламжийн орлого	1	Мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн.
5	Хандив, тусламжийн зарцуулалтын тайлан	1	Мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн.
6	Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан	1	Мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн.
7	Байгууллагын батлагдсан төсөв	1	Байгууллагын 2024 оны батлагдсан төсвийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.
8	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	6	Тайлант хугацаанд 3 удаагийн гүйлгээгээр нийт 39.0 сая төгрөгийн зарлагын гүйлгээ гарсныг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.
9	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	6	Тайлант хугацаанд 10 удаагийн гүйлгээгээр нийтдээ 244.3 сая төгрөгийн орлого орж ирснээс 8 удаагийн 207.9 сая төгрөгийн гүйлгээг мэдээлж, 2 удаагийн 36.4 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсан байна.
10	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	6	2024 оны 04, 06 дугаар саруудад төсөвт өөрчлөлт орсон мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.
Хөрөнгө оруулалт, худалдан авалт		21	
1	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл	6	Мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн байна.
2	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	1	Худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сард хугацаандаа мэдээлсэн байна. Уг төлөвлөгөөнд шууд худалдан авалтын 7 удаагийн 35.5 сая төгрөгөөр төлөвлөж мэдээлсэн.
3	Худалдан авах ажиллагааны тайлан	1	Хугацаа болоогүй. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт заасны дагуу худалдан авах ажиллагааны

			тайланг дараа оны буюу 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим системээр тайлагнана.
4	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт	1	Мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн байна.
5	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	6	Тайлант хугацаанд 2 удаагийн 30.3 сая төгрөгийн ажил үйлчилгээ хийгдснийг 04 дүгээр сард хугацаандаа бүрэн мэдээлсэн.
6	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл	6	Мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн байна.
Бусад		31	
1	Батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээлэл	6	2024 оны 01 дүгээр сард мэдээлсэн. Бусад саруудад мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн байна.
2	Аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний тайлан	1	Хугацаа болоогүй. Аймгийн Төрийн аудитын газраас өгсөн зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний тайланг 2024.07.01-ний дотор тайлагнахаар байсан.
3	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	6	Байгууллагын 2023 оны санхүүгийн аудитын тайланд өгсөн зөвлөмжийн дагуу хийх ажлын төлөвлөгөө гаргасныг 2024 оны 05 дугаар сард мэдээлсэн. Бусад саруудад мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн байна.
4	Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт	6	Мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн байна. Тус газрын чиг үүрэгт хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлс байхгүй болно.
5	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл	6	Тайлант хугацаанд байгууллагын удирдлага иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээнд ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж, холбогдох заалтыг тусгасан хэдий ч нийтэд мэдээлээгүй. Мөн зардал гаргах тухай шийдвэр гаргахдаа "Ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл" гаргаж нийтэд мэдээлээгүй байна.
6	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	6	Тайлант хугацаанд төр, хувийн хэвшил, иргэнтэй байгуулсан хамтран ажиллах, ажил гүйцэтгүүлэх гэрээ, мөнгө зарцуулсан шийдвэрийг мэдээлсэн боловч хугацаа хоцроосон байна.
Нийт дүн		87	

Тус байгууллага нь 2024 оны эхний хагас жилийн байдлаар шилэн дансанд 22 нэр төрлийн мэдээллийг 87 талбарт мэдээлэхээс 2 нэр төрлийн мэдээллийг 5 талбарт 3 удаа хугацаа хоцроож мэдээлсэн, мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг бүрэн хангасан байдлыг шалгахад 2 алдаа гаргасан байна. Үүнд:

1. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн мэдээлэл болон төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэлийг 2024 оны 06 дугаар сард хугацаа хоцроож мэдээлсэн.

2. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 удаагийн орлогын гүйлгээ буюу 36.4 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй.


3. Байгууллагын батлагдсан төсвийг хугацаа хоцроож мэдээлсэн.

4. Байгууллагын удирдлага иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээнд ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлж, холбогдох заалтыг тусгасан хэдий ч нийтэд мэдээлээгүй. Мөн зардал гаргах тухай шийдвэр гаргахдаа "Ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл" гаргаж нийтэд мэдээлээгүй байна.

5. Мөнгө зарцуулсан шийдвэрийг нийтэд мэдээлсэн боловч хугацаа хоцроосон.

Дотоод хяналтын дүнгээр тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт 97.7%-тай буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэв.

ТАЙЛАН БИЧСЭН:

ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН:  П.ЦОГЦЭЦЭГ

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:

ГАЗРЫН ДАРГА:

 Х.СОЁЛ-ЭРДЭНЭ

МЭДЭЭЛЭЛ ОРУУЛСАН:

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

 С.МӨНХТУЯА

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАЛУУЧУУД ТЕАТРЫН САНХҮҮГИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ДОТООД ХЯНАЛТЫН ТАЙЛАН**

2024.09.30

Д/д	Мэдээллийн нэр төрөл	Талбар -ын тоо	Бодит байдал, илэрсэн зөрчил, анхаарах асуудал
Төсөв ба гүйцэтгэл		35	
1	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал	6	2024 оны эхний хагас жидийн төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн талаарх мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн.
2	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт	6	2024 оны эхний хагас жилийн батлагдсан төсөв, гүйцэтгэл, хөтөлбөр, зориулалтын талаарх мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн.
3	Санхүүгийн тайлан	1	2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн.
4	Хандив, тусламжийн орлого	1	Мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн.
5	Хандив, тусламжийн зарцуулалтын тайлан	1	Мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн.
6	Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан	1	Мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн. Энэ талбарт үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн орлого, түүний зарцуулалтын талаарх мэдээллийг мэдээлээгүй байна.
7	Байгууллагын батлагдсан төсөв	1	Байгууллагын 2024 оны батлагдсан төсвийг хугацаандаа мэдээлсэн байна.
8	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	6	Тайлант хугацаанд гарсан 14 удаагийн 127.0 сая төгрөгийн зарлагын гүйлгээг бүрэн мэдээлсэн. Гүйлгээг мэдээлэхдээ тухай бүр буюу гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор мэдээлсэн.
9	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	6	Тайлант хугацаанд 23 удаагийн гүйлгээгээр нийт 1,993.7 сая төгрөгийн орлого орж ирснээс мэдээлэхээс 1 удаагийн 62.9 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй. Бусад гүйлгээг тухай бүр бүрэн мэдээлсэн.
10	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	6	Сар бүр төсвийн өөрчлөгдсөн хуваарийг оруулсан. 5 дугаар сард оруулах мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн.
Хөрөнгө оруулалт худалдан авалт		21	
1	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл	6	Мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн байна.
2	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 1 дүгээр сард мэдээлсэн. Шууд худалдан авалтын 17 удаагийн 78.9 сая төгрөгөөр төлөвлөж мэдээлсэн байна.
3	Худалдан авах ажиллагааны тайлан	1	Хугацаа болоогүй. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт заасны дагуу худалдан авах ажиллагааны тайланг дараа оны буюу 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим системээр тайлагнана.

4	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт	1	Мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн.
5	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	6	1 удаагийн 7.1 сая төгрөгийн даргын А/24 дүгээр тушаалаар зарцуулсан "Өнөд өвлөгдөх аялгуу" концертын тайзны материал худалдан авсан зардлыг мэдээлээгүй.
6	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл	6	Мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн.
Бусад		31	
1	Батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээлэл	6	Тайлант хугацаанд 15 удаагийн батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг мэдээлсэн.
2	Аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэн арга хэмжээний тайлан	1	Хугацаа болоогүй. Аймгийн Төрийн аудитын газраас өгсөн зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний тайланг 2024.07.01-ний дотор тайлагнахаар байсан.
3	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	6	Мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн.
4	Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт	6	Үзвэр үйлчилгээний хөнгөлөлт, чөлөөлөлтийн журмыг 6 дугаар сард мэдээлсэн.
5	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл	6	Тайлант хугацаанд байгууллагын дарга нь иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ, хөрөнгө мөнгө зарцуулсан тушаал шийдвэртэй холбоотой "Ашиг сонирхлын мэдэгдэл" гаргаж нийтэд мэдээлээгүй байна.
6	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	6	Тайлант хугацаанд төр, хувийн хэвшил, иргэнтэй байгуулсан хамтран ажиллах, ажил гүйцэтгүүлэх гэрээ, мөнгө зарцуулсан шийдвэрийг 3 дугаар сараас бусад бүх саруудад мэдээлсэн.
Нийт дүн		87	

Тус байгууллага нь 2024 оны хагас жилийн байдлаар шилэн дансанд 22 нэр төрлийн мэдээллийг 87 талбарт мэдээллүүдийг хугацаа хоцроолгүй мэдээлсэн ба мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг бүрэн хангасан байдлыг шалгахад 4 алдаа гаргасан байна. Үүнд:

1. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 23 удаагийн 1,993.7 сая төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлэхээс 1 удаагийн 62.9 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй
2. Тайлант хугацаанд байгууллагын дарга нь иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ, хөрөнгө мөнгө зарцуулсан тушаал шийдвэртэй холбоотой "Ашиг сонирхлын мэдэгдэл" гаргаж нийтэд мэдээлээгүй.

3. Таван сая төгрөгөөс дээш худалдан авалтын 1 удаагийн 7.1 сая төгрөгийн мэдээллийг мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн.
4. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлэхдээ харилцагч байгууллагуудын хаягийн мэдээллийг оруулаагүй.

Дотоод аудитын дүнгээр тус байгууллагад Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт 95.4 хувьтай "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэв.

ТАЙЛАН БИЧСЭН:

ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АСУУДАЛ
ХАРИУЦСАНАХЛАХ МЭРГЭЖИЛТЭН:


П.ЦОГЦЭЦЭГ

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:
БАЙГУУЛЛАГЫН ДАРГА:


А.БОЛОРСҮХ

МЭДЭЭЛЭЛ ОРУУЛСАН:
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ


М.ОТГОНБАЯР

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНД ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ДОТООД ХЯНАЛТЫН ТАЙЛАН**

2024.10.01

Д/д	Мэдээллийн нэр төрөл	Талбар -ын тоо	Бодит байдал, илэрсэн зөрчил, анхаарах асуудал
Төсөв ба гүйцэтгэл		35	
1	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал	6	2024 оны эхний хагас жилийн төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн талаарх мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн.
2	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт	6	2024 оны байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хөтөлбөр, зориулалтын талаарх мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн.
3	Санхүүгийн тайлан	1	2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн.
4	Хандив, тусламжийн орлого	1	06 дугаар сард мэдээлсэн.
5	Хандив, тусламжийн зарцуулалтын тайлан	1	06 дугаар сард мэдээлсэн.
6	Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан	1	Мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн. Энэ талбарт үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн орлого, түүний зарцуулалтын талаарх мэдээллийг мэдээлээгүй байна.
7	Байгууллагын батлагдсан төсөв	1	Байгууллагын 2024 оны батлагдсан төсвийг 01 дүгээр сард хугацаандаа мэдээлсэн.
8	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	6	Тайланг хугацаанд гарсан 2 удаагийн 47.2 сая төгрөгийн зарлагын гүйлгээг хугацаандаа бүрэн мэдээлсэн. Гүйлгээг мэдээлэхдээ тухай бүр буюу гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор мэдээлэх хугацааг 2 удаа хугацаа хоцроосон, харилцагчийн хаягийн мэдээлэл дутуу байна.
9	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	6	Тайланг хугацаанд орсон 7 удаагийн 309.7 сая төгрөгийн санхүүжилтийн орлогын гүйлгээг мэдээлэхээс 2 удаагийн 72.7 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй, мөн үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн орлогыг мэдээлээгүй.
10	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	6	04 дүгээр сард цалингийн зардал нэмэгдэж төсөвт тодотгол орсон өөрчлөлтийг мэдээлээгүй.
Хөрөнгө оруулалт худалдан авалт		21	
1	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл	6	Мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн.
2	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	1	Худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сард хугацаандаа мэдээлсэн ба шууд худалдан авалтыг 7 удаа хийгдэх 35.5 сая төгрөгөөр төлөвлөж хугацаандаа мэдээлсэн.
3	Худалдан авах ажиллагааны тайлан	1	Хугацаа болоогүй. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэгт заасны дагуу худалдан авах ажиллагааны

			тайланг дараа оны буюу 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим системээр тайлагнана.
4	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт	1	Мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн.
5	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	6	Тайлант хугацаанд 1 удаагийн 9.0 сая төгрөгийн худалдан авалтыг мэдээлээгүй. 1-4 дүгээр саруудад мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн мөн 5 болон 6 дугаар саруудад мэдээлэл оруулаагүй.
6	Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл	6	Мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн.
Бусад		31	
1	Батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээлэл	6	2024 оны 01 дүгээр сард мэдээлсэн. Бусад саруудад мэдээлэл байхгүй гэж мэдээлсэн байна.
2	Аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэн арга хэмжээний тайлан	1	2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг 2 дугаар сард Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан мэдээлэх талбарт мэдээлсэн.
